

УДК 94(470.47)+94(517)

1771 ОНЫ ИХ НҮҮДЛИЙН НЭГЭН ҮҮДЭЛ ШАЛТГААНЫ УЧИР

Батсуурь А.

Ph.D, хэл зохиолын тэнхимийн профессор,
Ховд их сургууль. Ховд, Монгол Улс
E-mail: a_batsuuri@ymail.com

Товч хураангуй

Монголчуудын нүүдэл ба суурьшлын түүхтэй холбоотой олон баримт бий. Түүний нэг бол 254 жилийн өмнө болсон Торгуудын их нүүдэл юм. Торгуудын их нүүдлийг эргэн дурсах түүхэн өдөр өнөөдөр тохиож байна. Увш хан 80 мянгаа цэргээ цуглуулж, Зүүнгарын зүг нүүхээ мэдэгдээд, Ижилийн хөвөөгөөр нутагласан бүх ардаа хураах даалгавар тэдэнд өглөө. 1771 оны 1 сарын 5-нд их нүүдэл хөдлөхийн урд шөнө гайтай цасан шуурга дэгдэж, Ижил мөрний мөс цөмөрсөнөөр баруун эрэгт нутаглаж байсан халимгууд хааны тушаалыг биелүүлж чадалгүй тэндээ үлджээ. Торгуудын энэ их нүүдэл 7 сар үргэлжилж, 4 мянган км замыг туулахдаа, Оросуудын тавьсан түмэн бэрхшээлтэй учирч, зам зуурын таарсан цус урсгасан олон дайн, өлсөгөлөнд сульдан ядарч, үхэж үргэдсээр 4 зун мянган торгуудаас зөвхөн 125 мянга нь Зүүнгарын говьд хөл тавьжээ. Наад зах нь гэхэд тэдний зам дахь бүх худгийг хордуулсан байсан гэдэг. Манжийн хаан тэднийг баяр ёслолын байдалтай угтаж аваад, Зүүнгарын говийг 10 мужид хувааж, Торгуудуудад захируулжээ. Ижил мөрний баруун эрэгт 15 мянган өрх буюу 70 орчим мянган Торгуудууд үлджээ.

Түлхүүр үг

Торгууд, халимаг, өөрд, их нүүдэл, буддын шашин, сүсэг бишрэл.

UDC 94(470.47) +94(517)

ONE OF THE CAUSES OF THE GREAT MIGRATION OF 1771

Batsuuri A.

Ph.D, Professor, Department of linguistics.

Hovd university. Khovd, Mongolia

E-mail: a_batsuuri@ymail.com

Annotation

There are many facts related to the history of Mongolian migration and settlement. One of them is the Great Migration of the Torguds, which took place 254 years ago. Today is a historic day to commemorate the great migration of the Torguds. Uvsh Khan gathered 80,000 troops and announced that he would move towards Dzhungar, and gave them the task of capturing all the rears living along the banks of the Izhili River. On January 5, 1771, on the night before the great migration, a terrible snowstorm broke out and the ice of the Izhyl river broke, and the whales living on the west coast could not obey the khan's orders and remained there. This great migration of the Torguds lasted for 7 months and covered 4,000 km. They were weakened and died from many bloodshed wars and starvation, and only 125000 of the 400000 Torguds set foot in Dzhungar Gobi. At least all the wells on their way were poisoned. The Manchu king welcomed them with a festive atmosphere and divided Dzungar Gobi into 10 provinces and subjugated them to Torguds. 15,000 households or about 70,000 Torguds remained on the west bank of the Izhyl River.

Key words

Torguds, Kalmyks, Oirats, great migration, Buddhism, piety.

О Р Ш И Л

Монгол орноо буддын шашин соёл гурван удаа дэлгэрч, мэдлэг ухаан, оюун билэг, соёл урлаг, зан үйл, амьдралын олон зүйлийн ай савд гүн гүнзгий нэвчин орж, монгол буддизм гэсэн биеэ даасан өнгө төрх, уламжлал залгамжийн холбоо бүхийгээр хөгжсөөр өнөө үед хүрч ирсэн билээ. Монгол хүний шүтэн бишрэх, сүсэг хүндлэлийн ариун шүтээн нь багш, ном, бурхан эрдэнэ болж нэгэнт хэвшин тогтсон учир, оройн дээд итгэл авралын цөм нь Бурханы шашин учраас сургаал номлол, зам мөрийг нь алдалгүй дагаж, өвөг дээдэс, ахас ихэс, ахан дүүсээ хайрлан хүндлэх, байгаль дэлхийтэйгээ шүтэн барилдаж оршсоор ирсэн нүүдэлчдийн оюуны хийгээд ахуйн соёлоо хадгалан үлдэх, эх хэлээрээ ярьж, унаган бичиг үсгээ сурч судлахыг эрхэм болгож ирсэн нь монгол хүний чин хүсэл, сэтгэл зүрхний мөнхийн эрмэлзлэл юм.

Түүхэн цаг хугацааны адбиш араншингийн эрхээр зүсэн зүйлийн хавчилга хяналт, халдлага дайралт, гадуурхан дээрэлхэх үйл явцын дунд амьдран суухад маш хүнд, амар тайван бус байдал нь халимаг хүмүүс, тэдний удирдах ноёд түшмэдийн сэтгэл санааг машид зовоож, хэрхэх учир, гарах арга замыг ямагт эрэлхийлж, болж бүтэх түвшиндээ шийдсээр ирсэн боловч яах ч аргагүй тулгалт, шахалт шаардлагыг эсэргүүцэх, санал үл нийлэх зүйлс байнга гарсаар байсан нь тэвчин тэсэх язгаараас давж, цаашдын зам мөр, явдал үйлсээ төлөвлөх, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагын өмнө тулж иржээ. Чухам энэ байдал хэзээнээс эхэлж, хэдийгээс идэвжиж, улс төр, нутаг дэвсгэрийн хүрээнд хэрхэн өрнөж байсныг тодруулан үзэж, 1771 оны их нүүдэл хийх болсон үүдэл шалтгааныг оюун санаа, итгэл бишрэл, үнэт зүйлсийн хүрээнд нэхэн тэнхэрүүлж, дүгнэлт өгөхийг зорив.

1. Эх нутгаасаа анх нүүсэн шалтгаан — шашны нөлөө

Зүүнгарын нутгаасаа алс очин нутаглах болсон ахны шалтгаан нь “Зүүнгарын дөрвөн Ойрадад эвдрэл болсон цагт Торгуудын тайш нь Хо өрлөг хэмээгч бээр “Тэр мэт нэг нэгнээ алж, албат нараа барснаас хол газар очиж, харь яст улсын ойр сууж, тэдэнтэй дайралдан олз авч явбаас дээр болой” ... шороон луу жилд (1628) өөрийн албат Торгууд ба Хошууд хийгээд Дөрвөд таван түмэн өрх улс авч, зургаан хөвүүнээ дагуулан Зүүнгар дахь нутгаа орхиод, наран шингэх зүгт мордов” (Сүхбаатар, 2022: 24) хэмээн өгүүлсэн байх бөгөөд үүний цаана сэтгэлийн их энэрэл, гай зовлонг албат иргэддээ амсуулахгүй гэсэн чин сүжиг хүмүүний бодлого, бодтойгоор хэрэгжсэн хэрэг юм.

Чухамхүү Хо өрлөг тэргүүтэн тайш, ноёдын энэхүү бодлого, чин хүсэл нь “Тийн төмөр луу жилд (1640 онд) Дөчин, Дөрвөн хоёр хуучин эвдрэлээуураад (болиод) санаа нэгтгэж, Шагжамуни тойны эцэг Инзан ринбучи хийгээд Анхоби (Акшоби) Манзушир, Амугашиди Манзушир хутагт [03] гэгээний өмнө Эрдэнэ засагт хаан, Түшээт хаан, Гүүш номын хаан, Эрдэнэбаатар хунтайж тэргүүлэн хаад, ноёд чуулж, “Их цааз” тогтооход Хо Өрлөг морилж, тэр баясгалант их үйлийг бүтээхэд байлцаад тогтоосон цаазыг нутагтаа авч ирж, албат нараа түүгээр барив” (Сүхбаатар, 2022: 24) хэмээн өгүүлсэн түүхэн баримтаас тов тодорхой харагдана.

“Ойрадын нутагт...харин ч бурхны шашны зан дадгал, ном судар ойрадад эрт дэлгэрснийг ойрад угсаат хүмүүсийн зан ааль, язгуурын урлаг, шашин номд гавьяа зүтгэл гаргасан мэргэдийн намтар түүх харуулдаг. Ойрадын ноёдын угийг дурдахдаа

Торгууд Ойрадад түрүүнд ирж түшсэн хаан нь Хайван хэмээх монголчилвоос Мэргэний эрхт гэсэн. Эдний хөвгүүн Сосуй хэмээх монголчилвол Буян тэтгэгч гэсэн хэмээн гарч байгаа юм. Торгуудын ноёдын дээд өвөг болох Хайван нь төвд нэртэй хүн юм” (Тэрбиш, 2008: 11). Энэ бүхнээс тухайн үеийн ойрадууд бурханы шашныг хүчтэй шүтэж байсан байна.

2. Оросын хаант засаг, орон нутгийн хавчлага шахалт

Торгуудын хант улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн асуудалд Оросны хаант засгаас тусгайлан оролцож, заавар шийдвэр өгч, нэгэн хэсэгтээ харилцан хамтын ажиллагаатай байсан юм. Тухайлбал Аюук хаан сууснаар хагас зууны турш Торгуудууд Европт нэрээ дуурьсгаж, Далай ламтай холбоо тогтоож, Их Петер хаан Ижилд ирэн, Аюуктай золгосон зэрэг үйл явдлыг дурдаж болно.

Дараахь үеийн хаан ширээний төлөөх тэмцэл, тэднийг хаан сууринд суулгах, хүлээн зөвшөөрөх зэрэгт Оросын хаант улсын засаг захиргаа, орон нутгийн ноёд түшмэдүүд ямар нэгэн хэмжээгээр оролцож, өөсдийн талд ашигтайгаар шийдвэрлэж байсан явдал бий. Мөн хил хязгаар, алба гувчуурын төдийгүй сургууль, шүтлэг бишрэлийн талаар үл нийцэх бодлого явуулж, удаа дараа хавчлага шахалт үзүүлж, эе эвдрэлцэх тохиолдол бишгүй гарч байжээ. Халимагуудыг үнэн алдартны шашинд оруулах явдал эрчимжиж, орос бичиг үсэгт хүчээр сургах явдал газар авсан нь үндэс угсаа, шашин соёлоо гэсэн ард олон, хан ноёдын дургүйцэл ихэд хүрч, үүний эсрэг бодлого боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлж байсан.

3. Халимаг хаадын бодлого, шашин төрийн үйл хэрэг, оюун санааны нөмөр нөлөө

Халимагийн хант улсыг Хо өрлөгөөс (?-1644) эхлэн Убаши хүртэл угсаа залгамжилсан зургаан хан төрийн эрхийг барьж байсан бөгөөд тухай тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр, өөрийн бодлого шийдвэрийг гаргаж, улс гэрээ төвхнүүлэн оршиж, Оросын хаан төрийн төр, засгийн газар, орон нутгийн засаг захиргааны ноёд түшмэдтэй харилцан эв зүйгээ ололцохыг хичээхийн хамт уугуул нутагт буй Зүүнгарын хаант улсын удам угсаа нэгт ойрадуудтайгаа харилцан элч төлөөлөгч зарах, өөрсдийн биесээр учран золгох, шашин төрийн хэрэг, буян номын үйл хэргийг тасралтгүй үргэлжлүүлж, сүсэг бишрэлийн удирдагч болох төвөдийн Далай, Банчин эрдэнэ нартай холбогдож байсан ажээ.

“1640 оны “Дөчин дөрвөн хоёрын цааз”, “Дондогдаш ханы хууль цааз” хоёрын хооронд эрх зүйн шууд залгамж холбоо буй нь сонирхол татаж байна. Хууль цааз-д төрөлх хэл, соёлоо дээдлэхийг ч чухалчлан заажээ. Тэгээд ч Торгуудууд эх нутгаасаа гарч Ижил мөрний сав нутагт ирж суурьшаад 100 гаруй жил болов. Энэ хугацаанд тэдний зарим нэг нь Христийн шашинд орох, хэл, соёлоо орхин гээх үзэгдлүүд ч гарч байлаа. Иймд хуульд ихэс дээдсийн хүүхдүүд арван хоёр нас хүртэл монгол бичиг сур, эс сургаваас эцгээс нь ял аваад багшид өгч сургахыг хатуу цаазалжээ (Батмөнх, 2022: 77).

ДҮГНЭЛТ

Тухайн он жилүүдэд халимаг хүмүүсийн дээдлэн шүтэж, итгэл үнэмшлийн цөм болж байсан шашин соёлын үзэл санаанд ноцтой хор хөнөөл учруулж мэдэх бодлогыг Оросын хаант засаг, бүс нутгийн засаг захиргаанаас баримталж иржээ.

Чухамхүү шашин соёл нь тухайн угсаатан, үндэстний хэл, бичиг, зан үйл, эдийн хийгээд оюуны соёлын үнэт зүйлсийг хадгалж байдаг цөм тогтолцоо юм. Шашин соёлоо үгүйсгэн гээх, уламжлалт өв соёлоо эзэнгүйдүүлэх нь тухай ард түмнийг бахархан дээдлэх үнэт зүйлсгүй болгох гэсэн маш нарийн далд бодлого, үйл ажиллагааг эсэргүүцэн тэмцэх боломж тун бага байсан зэрэг нь уугуул нутаг усаа тэмцэн очих шийдвэрийг гаргахаас өөр аргагүй болж, замд учрах аливаа саад бэрхшээлээс зайлах гарцгүй болсон нөцөл байдал, үзэл санааны чиг хандлагыг гол чиг баримтаа болгож 1771 оны их нүүдэл хийх нэгэн үүдэл санааы учир ийм ажгуу.

Н о м з ү й

Батмөнх, Б. (2022). Евроазийг дамнасан их нүүдэл. *Studia Regionalia Occidentalis Mongoliae-I*. Улаанбаатар.

Сүхбаатар, На. /Эрхлэн хэвлүүлсэн/ (2022). Халимаг хаадын туужийг хурааж бичсэн товч оршив. *Bibliotheca Oiratica-CXI*. Улаанбаатар.

Тэрбиш, Л. (2008). Ойрадын бурханы шашины товч түүх. *Bibliotheca Oiratica-XI*. Улаанбаатар.

References

Batmunkh, B. (2022). The Great Migration across Eurasia. *Studia Regionalia Occidentalis Mongoliae-I*. Ulaanbaatar (in Mongolian).

Sukhbaatar, Na. (2022). A collection of the chronicles of Halimag kings. *Bibliotheca Oiratica*. CXI. Ulaanbaatar (in Mongolian).

Terbish, L. (2008). A Brief History of Oirad Buddhism. *Bibliotheca Oiratica-XI*. Ulaanbaatar (in Mongolian).